САЛБАРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН АХЛАХ ШИНЖЭЭЧ Д.ГАНЧИМЭГИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам

Нэгжийн нэр: Салбарын хяналтын газар

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Зорилт 2.5.5.1: Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын бодлогыг үйл ажиллагааны стратегийн зорилтуудтай уялдуулан тодорхойлох, төлөвлөх, эрсдэлийн шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийж, хэрэгжүүлэх, дүгнэх, нэгдсэн удирдлагаар хангана.** | | | | | |
| 1 | **Арга хэмжээ 6.5.3.** Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Хяналт шалгалт хийх нийтлэг журамд санал өгөх; | 60 | 10 | 70 | |
| 2 | **Арга хэмжээ 6.5.4.** “Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах журам”-д нэмэлт өөрчлөлт оруулж, батлуулах | 60 | 10 | 70 | |
| 3 | **Арга хэмжээ 6.5.5.** Салбарын холбогдох хууль тогтоомж, техникийн зохицуулалт, норм нормативын баримт бичиг болон төсөл хөтөлбөрийн төсөлд санал өгөх. | 60 | 10 | 70 | |
| 4 | **Арга хэмжээ 6.5.6.** Салбарын хяналтын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, тайлагнах | 60 | 10 | 70 | |
| 5 | **Арга хэмжээ 6.5.7.** Удирдлагаас өгсөн цаг үеийн шинжтэй үүрэг даалгаврын дагуу ажиллах; | 51 | 9 | 60 | |
| **Зорилт 2.5.5.2: Хот байгуулалт, барилгын материал, өргөх байгууламж, техник, технологи, тоног төхөөрөмж, инженер геологи, барилга байгууламж, цэвэр ус, ариутгах татуурга, цахилгаан, дулаан хангамж, шугам сүлжээний зураг төсөл, угсралт, ашиглалтын явцад хууль тогтоомж, техникийн зохицуулалт, норм, нормативын баримт бичгийн хэрэгжилт, техникийн чанар аюулгүй байдлыг хангуулна.** | | | | | |
| 6 | **Арга хэмжээ 6.6.1.** Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 6 объектод төлөвлөгөөт шалгалт хийх;<br>АХ-2050- 2.5.11, | 51 | 10 | 61 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | *МУХТЖҮЧ-8.1.8, 9.3.3, ЗГҮАХ-2.4.3.4, 4.2.4.3,* | | | | |
| 7 | **Арга хэмжээ 6.6.2.** Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламж, бусад эх үүсвэрийн хөрөнгө оруулалтаар шинээр болон өргөтгөл, шинэчлэл хийгдэж байгаа төсөл, арга хэмжээний барилга байгууламжийн зураг төсөл, угсралтын ажлын чанар, техникийн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор урьдчилан сэргийлэх шалгалт хийх; *УХТЖҮЧ-9.3.2, 9.3.3, ЗГҮАХ-2.4.3.4* | 51 | 10 | 61 | |
| 8 | **Арга хэмжээ 6.6.3.** Соёл урлаг боловсролын байгууллагын барилга байгууламжийн чанар аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх; | 48 | 10 | 58 | |
| 9 | **Арга хэмжээ 6.6.4.** Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан хэрэгцээ, шаардлагыг хангуулах зорилгоор барилга байгууламжийн зураг төсөлд тусгуулах, угсралт, ашиглалтын чанар, аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх шалгалт хийх; *МУХТЖҮЧ-3.2.4.,* ЗГҮАХ-2.4.2.4 | 60 | 10 | 70 | |
| 10 | **Арга хэмжээ 6.6.7.** Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл, удирдлагаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийх; | 60 | 10 | 70 | |
| 11 | **Арга хэмжээ 6.6.8.** Өмнөх шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар өгсөн албан шаардлагын биелэлтийг хангуулахаар гүйцэтгэлийн хяналт шалгалт хийх; | 54 | 10 | 64 | |
| 12 | **Арга хэмжээ 6.6.10.** "Шар усны болон үерийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангуулах тухай" албан даалгавар боловсруулан батлуулж, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт хүргүүлж, биелэлтийг нэгтгэх; | 48 | 10 | 58 | |
| 13 | **Арга хэмжээ 6.6.11.** "Барилга байгууламжийн чанар аюулгүй байдлыг хангуулах тухай" албан даалгавар боловсруулан батлуулж, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт хүргүүлж, биелэлтийг нэгтгэх; | 60 | 10 | 70 | |
| 14 | **Арга хэмжээ 6.6.13.** Зөрчлийн талаарх гомдол мэдээллийг нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, хуулийн дагуу арга хэмжээ авах; | 60 | 10 | 70 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **Салбарын сургалт зохион байгуулах ажлын хүрээнд:** | | | | | |
| 15 | **Арга хэмжээ 8.2.13.** Салбарын хяналтын улсын байцаагч нарт зориулсан сургалтыг цахим болон танхимын зохион байгуулах; | 60 | 10 | 70 | |
| 16 | **Арга хэмжээ 8.2.17**. Иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн хариутай албан бичиг, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, хөтлөгдөж дууссан баримт бичгийг архивт хүлээлгэн өгөх. | 60 | 10 | 70 | |
| **Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт** | | | | | |
| 17 | **Үүрэг даалгавар 1:** Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын дагуу улсын байцаагчийн эрх олгох, цуцлах тушаал, танилцуулга гаргах. | 54 | 10 | 64 | |
| **Дундаж оноо:** | | | | 66.23 | |

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1 | **Арга хэмжээ 1:** ШХИС-д эрх зүйч мэргэжлээр суралцах | 100%. | 15 | |
| **Дундаж оноо** | | | 15. | |

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Нэгжийн даргын үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо) | Үнэлгээний багийн • хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1. | Хандлага, ёс зүй | 7 | |
| 2. | Дүн шинжилгээ хийх | 7 | |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 7 | |
| 4. | Хариуцлагатай байдал | 7 | |
| 5. | Ажлын цаг ашиглалт | 7 | |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | | |
| 6. | Мэргэжлийн ур чадвар 1. | | |
| 7. | Мэргэжпийн ур чадвар 2. | | |
| 8. | Мэргэжлийн ур чадвар 3. | | |
| **Дундаж оноо** | | 7 | |

**4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Хамт олны үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Хамт олны үнэлгээ (0-8 оноо) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1. | Хандлага, ёс зүй | 7.8 |
| 2. | Багаар ажиллах | 7.8 |
| 3. | Харилцаа | 7.8 |
| **Дундаж оноо** | | 7.8 |

**5.Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)* | *(70 хүртэлх оноо)* 66.23 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | *(15 хүртэлх оноо)* 15 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Нэгжийн даргын үнэлгээ)* | *(7 хүртэлх оноо)* 7 |
| 4. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Хамт олны үнэлгээ)* | *(8 хүртэлх оноо)* 7.8 |
| 5. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт *(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | *(..... оноо)* 96.03 |
| **Нийт оноо =** ( Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо **+** Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо **+** Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)*) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо **+** Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | | |

***Үнэлгээ өгсөн:*** ***Нэгжийн дарга***

Салбарын хяналт-шинжилгээ, Үнэлгээ, дотоод аудитын газар ................................ /Б.НАЙРАМДАЛ/
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

*2025.12.09 (огноо)*

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:*** ***Төрийн жинхэнэ албан хаагч:***

СХШҮДАГ-ын шинжээчийн албан үүргийг түр орлон гүйцэжтгэгч ................................ /Д.ГАНЧИМЭГ/
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

*2025.12.09 (огноо)*

***Үнэлгээг хянасан:***

*Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:*

Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ................................ /Б.БАТ-ЭРДЭНЭ/
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

*2025.12. .... (огноо)*

*Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:*

ТЗУГ-ын ахлах шинжээчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ................................ /Т.ЯНЖМАА/
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

*2025.12. ....(огноо)*

***Үнэлгээг баталгаажуулсан:*** ***Төсвийн шууд захирагч***

ТНБД-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ................................ /М.БАЯРАА/
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

ХТҮ7852 9024070690 9129308

*2025.12. .... (огноо)*

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 6 дугаар хавсралт*

# БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ САЛБАРЫН ХЯНАЛТЫН ГАЗРЫН ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЯНАЛТ ХАРИУЦСАН АХЛАХ ШИНЖЭЭЧ, УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ Д.ГАНЧИМЭГИЙН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт / | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлт хувь |
| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 2.5.5.1: Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын бодлогыг үйл ажиллагааны стратегийн зорилтуудтай уялдуулан тодорхойлох, төлөвлөх, эрсдэлийн шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийж, хэрэгжүүлэх, дүгнэх, нэгдсэн удирдлагаар хангана.** | | | | | | | |
| 6.5.3 | Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Хяналт шалгалт хийх нийтлэг журамд санал өгөх; | -Хууль-1<br>-Журам-1 | Төрийн хяналт шалгалтын тухай хуульд 7 санал, Хяналт шалгалтын нийтлэг журамд 2 санал өгсөн. | Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Хяналт шалгалт хийх нийтлэг журамд санал өгсөн байна. | Хяналт, үнэлгээний үндэсний хорооны даргын 2024.12.16-ны А/23 дугаар тушаалаар ажлын хэсэгт орж ажиллан Төрийн хяналт шалгалтын тухай хуульд 8 санал, Хяналт шалгалтын нийтлэг журамд тусгуулахаар 3 саналыг Хяналт, үнэлгээ үндэсний хороонд 2025.03.24-ний 11/1015 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | 2025.01.01<br>2025.03.17 | 100 |
| 6.5.4 | "Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах журам"-д нэмэлт өөрчлөлт оруулж, батлуулах | -Журам-1 | БХБС-ын 2023 оны 259 дугаар тушаалаар "Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах | "Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулж, | Барилгын тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-д заасны дагуу "Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах журам"-ийн хэрэгжилтийг хангах зорилгоор "Барилга байгууламжийн ашиглалт (ногоон, шар, улаан)-ын гэрчилгээ загвар"-ыг нэмэлтээр | 2025.01.02<br>2025.06.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | журам"-ын нөлөөллийн шинжилгээ хийж, улсын нэгдсэн бүртгэлд бүргүүлэх албан бичгийг хүргүүлсэн. | батлуулсан байна. | боловсруулан санал авахаар ХЗДХЯ, ЭХЯ, ЗТЯ, ЦХИХХЯ-д 2025.04.17-ны өдрийн 11/1365 тоот албан бичгийг, 2025.04.17-ны өдрийн 1366 тоот албан бичгийг аймгийн ГХБХБГ, ХШГ, ХБХСГ, Монголын барилгын инженерүүдийн холбоо ТББ-д тус тус хүргүүлсэн.<br>Тус албан бичгийн дагуу ХЗДХЯ, ЗТЯ, ЦХИХХЯ, Дорноговь, Сэлэнгэ аймгийн ГХБХБГ, нийслэлийн ХБХСГ-аас саналыг албан бичгээр ирүүснийг нэгтгэн журмын хавсралтад тусгасан, танилцуулга, нөлөөллийн шинжилгээ хийж, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025.05.22-ны өдрийн 118 дугаар тушаалаар батлуулсан, ХДХЯ-ны улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхээр 2025.05.26-ны өдрийн 01/2010 дугаар албан бичгээр хүргүүлсэн.<br>Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2025.06.06-ны өдрийн 1/3116 дугаар албан бичгээр "Журмын хавсралтад нэмэлт оруулах тухай" ХББОСС-ын 2025.05.22-ны өдрийн 118 дугаар тушаалыг үндэслэн захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 6710 дугаарт бүртгэлтэй нэмэлтийг хүлээн авч, санд холбогдох хөдөлгөөн хийж бүртгэсэн.<br>"Журмын хэрэгжилтийг хангаж ажиллах тухай" Аймаг, нийслэлийн Засаг дарга, НХШГ, аймгийн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ГХБХБГ-т 2025.06.12-ны өдрийн 01/2323 дугаар албан бичгийн хамт, тушаал, барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээний загварыг тус тус хүргүүлсэн.<br>Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээг 4 ширхэгийг олгосон. /Дорноговь 2, Дундговь 2/<br>*Санал:* 2026 онд барилга байгууламжийн гэрчилгээжүүлэх ажлыг эрчимжүүлэх, нэгдсэн сургалт зохион байгуулах шаардлагатай. | | |
| 6.5.5. | Салбарын холбогдох хууль тогтоомж, техникийн зохицуулалт, норм нормативын баримт бичиг болон төсөл хөтөлбөрийн төсөлд санал өгөх. | -Хууль-3<br>-Норм нормативын баримт бичиг-3 | Салбарын холбогдох 4 хууль, 1 дүрэм, 1 журмын төсөлд өгсөн. | Салбарын холбогдох хууль тогтоомж, техникийн зохицуулалт, норм нормативын баримт бичгийн төсөлд санал өгсөн байна. | Салбарын холбогдох 6 хууль, 3 норм ба дүрэм, 5 журам, 1 стандартын төсөлд санал өгч, 3 хуулийн шинэчилсэн найруулга, 3 норм ба дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсэг орж ажиллаж байна. Мөн 1 журмын нэмэлт өөрчлөлтийн боловсруулан батлуулж, улсын бүртгэлд бүртгүүлсэн.<br>*а/ Хуулийн төсөл:*<br>1.Хаягжуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд 11 заалт бүхий саналыг боловсруулан ХББЗГ-т ERP цахимаар болог дотоод албан бичгээр 2025.01.06-ны өдөр хүргүүлсэн.<br>2. Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын ХББОСС-ын 2025.09.04-ний өдрийн тушаалаар 2025.09.29, 2025.10.24-ний өдөр ажлын хэсгийн хуралд | 2025.01.02<br>2025.12.09 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | орж ажиллан, үзэл баримтлал 3, хуулийн төсөлд 28 заалт саналыг ажлын хэсгийн нарийн бичгийн даргад хүргүүлсэн.<br>3.Хот, суурин газрын дахин хөгжүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн ажлын хэсэгт ХББОСС-ын 2024.12.02-ны өдрийн 110 дугаар тушаалаар ажлын хэсэгт орж ажиллаж байна. Үзэл баримтлалд тусгуулах 2 заалт бүхий саналыг 2025.12.05-ны өдөр ажлын хэсэгт цахимаар хүргүүлсэн.<br>4.Хяналт, үнэлгээний үндэсний хорооны даргын 2024.12.16-ны А/23 дугаар тушаалаар ажлын хэсэгт орж ажиллан Төрийн хяналт шалгалтын тухай хуульд 8 саналыг тусгуулахаар Хяналт, үнэлгээ үндэсний хороонд 2025.03.24-ний 11/1015 дугаар албан бичгээр хүргүүлсэн.<br>5.ХББОССайдын 2024.12.02-ны өдрийн 107 дугаар тушаалаар Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн ажлын хэсэгт орж ажиллан 2 заалт бүхий санал өгч ажилласан.<br>6.Барилгын ерөнхий хуулийн ажлын хэсэгт удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу 2 удаа оролцож, үзэл баримтлал болон хуулийн төсөлд тусгах 10 багц бүхий саналыг танилцуулсан.<br>*б/ Журам ба норм ба дүрэм* | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 1.Хяналт шалгалтын нийтлэг журамд 3 саналыг Хяналт, үнэлгээ үндэсний хороонд 2025.03.24-ний 11/1015 дугаар албан бичгээр хүргүүлсэн.<br>2.ХББОСС-ын 2025.05.07-ны өдрийн 102, 2025.09.08-ны өдрийн 208 дугаар тушаалаар Улсын онцгой комиссын 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 4 дүгээр хуралдааны шийдвэрийн 2 дахь хэсгийн 2.1, 2.2, 2.3, 2.4, 2.5, 2.6, 2.7, 2.8-д өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангах ажлын хүрээнд "Шатахуун түгээх станц. Галын аюулгүйн норм" /БНбД 21-07-14/-ийн 5.8, 19.1, хүснэгт 7, "Хийн хангамж" /БНбД 42-01-19/-ын $8.124^7$, $8.126^9$ гэсэн заалтуудад нэмэлт өөрчлөлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт орж ажиллан 2025.09.18-ны өдрийн хуралд оролцож, саналыг өгч, нэмэлт өөрчлөлт оруулах 2.1, 2.6-д заалтын хүрээнд судалгааны ажлыг хийж гүйцэтгэж ажлын хэсэгт 2025.09.30-ны өдрийн хуралд танилцуулахаар бэлтгэж танилцуулсан. Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр бэлгэл ажлын хангаж байна.<br>3.БХБСайдын 2023 оны 259 дүгээр тушаалаар "Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах журам"-ны хавсралт "Барилга байгууламжийн ашиглалтын | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | гэрчилгээний загвар"-ыг болосруулан ХББОСС-аар 2025 оны 118 дугаар тушаалаар батлуулсан, улсын бүртгэлд бүртгүүлэхээр ХЗДХЯ-д хүргүүлж, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2025.06.06-ны өдрийн 1/3116 дугаар албан бичгээр "Журмын хавсралтад нэмэлт оруулах тухай" ХББОСС-ын 2025.05.22-ны өдрийн 118 дугаар тушаалыг үндэслэн захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 6710 дугаарт бүртгэлтэй нэмэлтийг хүлээн авч, санд холбогдох хөдөлгөөн хийж бүртгэсэн.<br>4.Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх экспертэд Тавигдах шаардлага, түүнийг өрсөлдөөний журмаар сонгон шалгаруулж, эрх олгох журмын төсөлд тусгуулах 13 санал, зөвлөмжийн хамт ББМБЗГ-ын шинжээч Б.Гандолгорт 2025.10.08-ны өдөр ERP-аар хүргүүлсэн.<br>5.Импортлох, экспортлох согтууруулах ундааны чанар, аюулгүй байдалд хяналт тавих журмын төсөлд тусгуулах 1 саналыг 2025.09.29-ний өдөр Хуулийн хэлтсийн ахлах шинжээч Ц.Батчимэгт ERP-аар хүргүүлсэн.<br>6.Барилга байгууламжийн норм, нормативын сангийн журмын төсөлд 2 заалт саналыг ББМБЗГ-т 2025.08.22-ны өдөр өгсөн. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 7.СХОСБЗГ-аас ирүүлсэн дотоод албан бичигт дурдсан "Гал түймэр унтраах аврах анги, стандарт тавих шаардлага" стандартын төслийг судалж танилцан 2025.08.01-ний өдөр ERP-аас 5 заалт бүхий саналыг хүргүүлсэн. | | |
| 6.5.6. | Салбарын хяналтын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, тайлагнах | Төлөвлөгөөг батлуулж, тайлагнасан | Салбарын хяналтын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловруулж, тайлагнасан. | Төлөвлөгөөг боловсруулж, тайлагнасан байна. | Салбарын хяналт газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр ТЗУГ-т дотоод албан бичгээр хүргүүлж, Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан.<br>ХББОСЯ-ны шинэ бүтэц батлагдсантай холбоотой удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу Салбарын хяналтын төлөвлөгөөний төслийг боловсруулан 2025.08.12-ны өдөр ахлах шинжээч Д.Мөнгөнсувд, А.Гэрэлт-Од нарт хүргүүлсэн.<br>ТЖАХ-ын 2025 оны хагас жилийн тайланг ХШҮДАГ-т гарган хүргүүлсэн.<br>Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын хот байгуулалт, барилгын төлөвлөлтийн хяналт хариуцсан ахлах шинжээч, улсын ахлах байцаагч Д.Ганчимэгийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хагас болон жилийн эцсийн тайланг гаргаж, тайлагнасан. | 2025.01.02<br>2025.12.09 | 100 |
| 6.5.7. | Удирдлагаас өгсөн цаг үеийн шинжтэй | Удирдлагаас өгсөн цаг үеийн | Удирдлагаас өгсөн цаг үеийн шинжтэй үүрэг | Удирдлагаас өгсөн цаг үеийн шинжтэй үүрэг | Удирдлагаас өгсөн 12 үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж ажилласан. Үүнд. | 2025.01.02<br>2025.12.09 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үүрэг даалгаврын дагуу ажиллах; | шинжтэй үүрэг даалгаврын хувь | даалгаврын дагуу 2 ажлыг хийж гүйцэтгэсэн. | даалгаврыг 100 хувь биелүүлсэн байна. | 1.Барилга байгууламжийн норм нормативын сангийн үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөний төсөлд тусгах 3 саналыг ББМБЗГ-т 2025.01.03-ны өдрийн 08/02 дугаар дотоод албан бичгээр хүргүүлж, нормчлолын сангийн төлөвлөгөөнд тусгуулсан.<br>2.Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын дагуу “Хэрэглэгч, орон сууц, барилга” сэдэвт хэлэлцүүлэгт 2025.03.25-ны өдөр “Барилга байгууламжийн чанар аюулгүй байдал” сэдвээр илтгэл мэдээллийг хийсэн.<br>3.ХББОСС-ын 13 удаагийн тушаалаар 31 улсын байцаагчийн эрхийг цуцалж, 26 эрх олгосон.<br>4.Хяналт, үнэлгээний үндэсний хорооны зөвлөлийн хуралд 2025.03.25-ны өдөр оролцон санал өгч ажилласан.<br>5.СХГ-ын 2026 оны үйл ажиллагааны төсвийн саналыг СХОГ-т 2025.05.28-ны өдрийн 11/1177 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>6.Удирдагаас өгсөн үүргийн дагуу ХББОСЯ-ны 2025-2028 оны стратеги төлөвлөгөөний төсөлд СХГ-ын стратеги төлөвлөгөөний 3 зорилт, 8 арга хэмжээний төслийг боловсруулсан.<br>7.”Барилга, дэд бүтцийн салбарын хяналт шалгалтын тогтолцоо” хэлэлцүүлгийг 2025.04.16-ны өдөр нийслэлийн ХШГ, ХБХСГ-тай хамтран зохион байгуулж, “Хяналт шалгалтын нэгдсэн тогтолцооны талаар төрөөс баримтлах | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бодлого” сэдэвт илтгэл мэдээллийг бэлтгэсэн.<br>8.ХББОСС болон аймаг, нийслэлийн Засаг даргын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулах гэрээний төсөлд 4 заалт саналыг ТЗУГ-т өгсөн.<br>9.Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт 2025.08.25-ны өдрийн “Улсын байцаагчийн томилох, холбогдох арга хэмжээг авч, хамтран ажиллах тухай” 01/3220 дугаар албан бичгийг хүргүүлсний дагуу 9 аймаг, нийслэлээс хариуг ирүүлж, саналыг нэгтгэж, ХББОССалбарын хяналтын тогтолцооны судалгаа боловсруулж, дүн шинжилгээ хийсэн.<br>10.Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт 2025.08.25-ны өдрийн “Албан даалгаврын хэрэгжилтийг хангах тухай” 01/3219 дугаар албан бичгийг хүргүүлсэн.<br>11.ХББОСЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын баталсан 2025 оны Б/127, Б/128 дугаар тушаалаар АТТ, чиг үүрэг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт орж ажиллан салбарын хяналтын 10 албан хаагчийн АТТ, чиг үүргийг боловсруулан ажлын хэсэгт 2028.08.19-ний өдөр ТЗУГ болон нарийн бичиг хүргүүлсэн.<br>12.ХЗДХЯ-иас ирүүлсэн “Засгийн газрын тогтоолын төсөл санал авах тухай” албан бичиг, ЗГ-ын | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тогтоолын төслийг судалж танилцан 2025.09.19-ний өдрийн 01/3519 дугаар албан бичгээр төсөл санал өгч, хариуг хүргүүлэв. | | |
| **Зорилт 2.5.5.2: Хот байгуулалт, барилгын материал, өргөх байгууламж, техник, технологи, тоног төхөөрөмж, инженер геологи, барилга байгууламж, цэвэр ус, ариутгах татуурга, цахилгаан, дулаан хангамж, шугам сүлжээний зураг төсөл, угсралт, ашиглалтын явцад хууль тогтоомж, техникийн зохицуулалт, норм, нормативын баримт бичгийн хэрэгжилт, техникийн чанар аюулгүй байдлыг хангуулна.** | | | | | | | |
| 6.6.1. | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 6 объектод төлөвлөгөөт шалгалт хийх;<br>АХ-2050- 2.5.11, *МУХТЖҮЧ-8.1.8, 9.3.3, ЗГҮАХ-2.4.3.4, 4.2.4.3,* | -Шалгалт хийсэн объектын гүйцэтгэлийн хувь<br>-Хяналт шалгалтын баримт бичгийн хэрэгжилтийн хувь | 1.Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 79 дүгээр тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны А/74 дугаар тушаалаар батлагдсан.<br>Төлөвлөгөөт хяналт шалгалтыг 6 объектод хийж, хяналт шалгалтын баримт бичгийн хэрэгжилт 70 хувьтай. | Төлөвлөгөөт шалгалтыг 6 объектод хийж гүйцэтгэсэн байна. | 1.ХҮҮХ-ны даргын баталсан 2024 оны 02 дугаар тушаалаар батлагдсан хяналт шалгалтын төлөвлөгөө, ХББОСС-ын 2024 оны 119 дүгээр тушаалтаар батлагдсан хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалт, 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу “Төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай” удирдамжийг боловсруулан Салбарын улсын ерөнхий байцаагчаар 2025.01.15-ны өдрийн 02-00/04 дүгээр удирдамжийг батлуулан аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, нийслэлийн Хяналт шалгалтын газарт 2025.01.15-ны өдрийн 11/175 дугаар албан бичгээр хүргүүлсэн.<br>2.Төлөвлөгөөт 7 объектод хяналт шалгалт төлөвлөснөөс 2 байгууллага, 3 төслийн нэгж, 2 аж ахуйн нэгжийн 7 объектод хяналт шалгалтыг хийж, 5 албан шаардлагыг хүргүүлж, биелэлт 95 хувьтай. Үүнд:<br>1.“Ногоон нуур–1008 айлын орон сууцны төсөл”-ийн 8 блок болон нэгдсэн гараашийн барилгад 2025.04.11-ний өдөр хяналт, шалгалт хийж гүйцэтгэн улсын ахлах байцаагчийн 2025.04.25-ны өдрийн 02-00- | 2025.01.02<br>2025.12.09 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 00/001 дугаартай 18 заалт бүхий албан шаардлагыг төслийн нэгж, ерөнхий гүйцэтгэгч БНХАУ-ын “Хятадын хоёр дахь Металлурги групп корпораци” ХХК, зураг төсөл зохиогч “Интеллект Тауэр” ХХК-уудад хүргүүлсэн. Тус албан шаардлагын биелэлтийг “Ногоон нуур–1008 айлын орон сууцны төсөл”-ийн нэгжээс 2025.07.01-ний өдрийн А/345 дугаар албан бичгээр ирүүлсэн бөгөөд биелэлт 95 хувийн гүйцэтгэлтэй.<br>2.Солонго 1, 2 төслийн хүрээнд хэрэгжиж буй 63 блок барилгад хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн 2025.05.12-ны өдрийн 02-00-01/003/87 дугаартай 14 заалт бүхий албан шаардлагыг ТОСК, зураг төсөл зохиогч “Mooyoung CM”-ийн төлөөний газар, “Интеллект тауэр” ХХК-д, ерөнхий гүйцэтгэгч БНСУ-ын ”Колон глобал корпораци” ТХҮГ, “Гранд Слаб инвест” ХХК-дад хүргүүлсэн. Тус албан шаардлагын биелэлтийг “ТОСК” ТӨХХК-иас 2025.06.30-ны өдрийн 1/714 дугаар албан бичгээр ирүүлсэн бөгөөд биелэлт 90 хувийн гүйцэтгэлтэй.<br>3.Польш Улсын хөнгөлөлтэй зээлээр хэрэгжиж буй Баян-Өлгий, Завхан, Увс аймгийн цэвэрлэх байгууламжид хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн 2025.05.29-ний өдрийн 02-00-03/001/94 дугаар албан шаардлагыг төслийн нэгж, зохиогч, гүйцэтгэгч байгууллагуудад хүргүүлсэн. “Аймгуудын бохир ус цэвэрлэх | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл”-ийн төсөл хэрэгжүүлэх нэгжээс 2025.06.18-ны өдөр албан бичгээр ирүүлсэн бөгөөд 3 заалтын биелэлт 96 хувийн гүйцэтгэлтэй.<br>4.Увс аймгийн Улаангом хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн 2025.05.31-ний өдрийн 02-00-01/003/95 дугаартай 8 заалт бүхий албан шаардлагыг Увс аймгийн ГХБХБГ-т хүргүүлж, 2025.06.20-ны өдөр албан бичгээр ирүүлсэн бөгөөд биелэлт 86 хувийн гүйцэтгэлтэй.<br>5.“Эко констракшн” ХХК-ийн СБД-ийн 1-р хороо, үйлчилгээтэй, орон сууцны барилгад хяналт шалгалтыг хийж барилгыг Зөрчлийн тухай хуулиар үйл ажиллагааг 2024 онд зогсоож, зөрчлийн үр дагаврыг арилгуулахаар 2025.03.06-ны өдөр ЭБАТ-ны шийдвэрээр Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд шилжүүлсэн.<br>6.Байгалийн түүхийн музейн барилгад төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн Хот байгуулалт, барилгын төлөвлөлтийн чиглэлээр 5 заалт зөрчил, шаардлагыг өгч, 2025.09.01-ний өдрийн 02-00-01-007/166 дугаар нэгдсэн албан шаардлагыг Соёлын яаманд хүргүүлсэн. 2025.06.20-ны өдөр албан бичгээр ирүүлсэн бөгөөд биелэлт 86 хувийн гүйцэтгэлтэй. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 7.“Эл Си Ди Эл” ХХК-ийн аялал жуулчлалын цогцолбор барилгад төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Барилгын хөгжлийн төв, Хот байгуулалт, хотын стандартын газар, нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд 2025.08.27-ны өдрийн “Тайлбар, мэдээлэл авах тухай” 08/3175, 08/3176, 08/3177, 08/3179, 08/3195 дугаар албан бичгийг хүргүүлж, биелэлт ирүүлсний дагуу Зөрчлийн тухай хуулиар үйл ажиллагааг 2024 онд зогсоож, зөрчлийн үр дагаврыг арилгуулахаар 2025 оны ЭБАТ-ны шийдвэр, албан бичгээр Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд шилжүүлсэн.<br>8. 10 аймгийн дулааны станцын төсөд 2025.04.09-ний өдрийн “Төлөвлөгөөт хяналт шалгалт хийхтэй холбогдуулан байгууламжийн явц, мэдээллийг ирүүлэх тухай” 11/1244 тоот албан бичиг хүргүүлсний дагуу 2025.04.14-ний өдрийн А/59 тоот албан бичгээр барилга байгууламжийн угсралтын ажил зогссон эхлээгүй талаар хариуг ирүүлсэн. | | |
| 8.2.2. | Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламж, бусад эх үүсвэрийн хөрөнгө оруулалтаар шинээр болон өргөтгөл, шинэчлэл хийгдэж | -Шалгалт хийсэн объектын гүйцэтгэлийн хувь<br>-Хяналт шалгалтын баримт бичгийн | 1.Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 79 дүгээр тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2023 | Төлөвлөгөөт шалгалтыг 2 объектод хийж гүйцэтгэсэн байна. | 1.ХҮҮХ-ны даргын баталсан 2024 оны 02 дугаар тушаалаар батлагдсан хяналт шалгалтын төлөвлөгөө, Хот байгуулалт, барилга, хот байгуулалтын сайдын 2024 оны 119 дүгээр тушаалтаар батлагдсан хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалт, | 2025.01.02<br>2025.12.09 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгаа төсөл, арга хэмжээний барилга байгууламжийн зураг төсөл, угсралтын ажлын чанар, техникийн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор урьдчилан сэргийлэх шалгалт хийх;<br>*УХТЖҮЧ-9.3.2, 9.3.3, ЗГҮАХ-2.4.3.4* | хэрэгжилтийн хувь | оны А/74 дугаар тушаалаар батлагдсан.<br>Төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг 4 объектод хийж, хяналт шалгалтын баримт бичгийн хэрэгжилт 70 хувьтай. | | 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Улсын төсөв болон орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламж, бусад эх үүсвэрийн хөрөнгө оруулалтаар шинээр баригдаж байгаа өргөтгөл, шинэчлэл хийгдэж байгаа төсөл, арга хэмжээний барилга байгууламжийн зураг төслийн боловсруулалт, баримт бичгийн бүрдэл, угсралтын ажлын чанар, шинээр болон шилжүүлж угсарсан өргөх байгууламжийн угсралт, ашиглалт, техникийн аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай удирдамжийг боловсруулан Салбарын улсын ерөнхий байцаагчаар 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 02-00/05 дугаар удирдамжийг батлуулан аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, нийслэлийн Хяналт шалгалтын газарт 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 11/175 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>2.Тус удирдамжийн дагуу “Номдот” ХХК-ийн үйлчилгээтэй орон сууц, “Од театр” ХХК-ийн үйлчилгээний барилга, “Ийст гарден” ХХК-ийн үйлчилгээтэй, орон сууц барилгуудад урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн 1 албан шаардлага, 1 дүгнэлт, ХББОСС-ын албан даалгаврыг өгсөн, биелэлт 92 хувьтай.<br>3.Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилт, 2023, 2024 онд олгосон | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 1311 архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зураг, барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний олголтын байдалд хяналт шалгалтыг хийж 581 зөрчлийг илрүүлж, 310 зөрчлийг арилгуулсан. | | |
| 6.6.2. | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан хэрэгцээ, шаардлагыг хангуулах зорилгоор барилга байгууламжийн зураг төсөлд тусгуулах, угсралт, ашиглалтын чанар, аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх шалгалт хийх;<br>*МУХТЖҮЧ-3.2.4.,*<br>ЗГҮАХ-2.4.2.4 | -Шалгалт хийсэн объектын гүйцэтгэлийн хувь<br>-Хяналт шалгалтын баримт бичгийн хэрэгжилтийн хувь | 2024 онд 4 объектыг урьдчилан сэргийлэх шалгалт хийж гүйцэтгэн, хяналт шалгалтын баримт бичгийн хэрэгжилт 75 хувьтай. | Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг 3 объектод хийж гүйцэтгэнэ. | 1.ХҮҮХ-ны даргын баталсан 2024 оны 02 дугаар тушаалаар батлагдсан хяналт шалгалтын төлөвлөгөө, Хот байгуулалт, барилга, хот байгуулалтын сайдын 2024 оны 119 дүгээр тушаалтаар батлагдсан хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалт, 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан хэрэгцээ, шаардлагыг хангуулах зорилгоор барилга байгууламжийн зураг төсөл, угсралт, ашиглалтын чанар, аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай удирдамжийг боловсруулан Салбарын улсын ерөнхий байцаагчаар 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 02-00/06 дугаар удирдамжийг батлуулан аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, нийслэлийн Хяналт шалгалтын газарт 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 11/175 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>2.Тус удирдамжийн дагуу улсын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл, аюулгүй орчинг бүрдүүлэх зорилгоор улсын хэмжээнд 321 иргэн, ААНБ-ын | 2025.01.02<br>2025.12.09 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шинээр баригдаж буй 109, ашиглагдаж байгаа 212 барилгад хяналт шалгалт хийж гүйцэтгэн 1447 зөрчил илрүүлэн 1401 зөрчлийг арилгуулж, 131 албан шаардлага, 20 дүгнэлт, 696 зөвлөмж өгч, 170 барилгын зураг төсөлд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан төлөвлөлтийг тусгасан, 198 налуу зам, 151 тэмдэг тэмдэглэгээ, 171 хөтөч зам, 140 ариун цэврийн өрөө, 170 авто зогсоол тус тус хийлгүүлсэн. | | |
| 6.6.7. | Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл, удирдлагаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийх; | Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар болон өргөдөл гомдол, ирсэн хүсэлтийн шийдвэрлэлтийн хувь | Удирдлагын өгсөн 2 үүрэг даалгавар болон иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн 10 хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээллийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн 100 хувь шийдвэрлэсэн. | Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар болон өргөдөл гомдол, ирсэн хүсэлтийг 100 хувь шийдвэрлэсэн байна. | Тайлант хугацаанд 11 төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж .<br>1.Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яамнаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2025 оны 02-00/01 дүгээр удирдамжийн дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 12 дугаар багт шинээр баригдаж буй “Очин начин” ХХК, “Юу Бюльд мастер” ХХК-ийн захиалгатай, “Аутсайд сервес” ХХК-ийн гүйцэтгэж буй А2 блок орон сууцны барилгад хяналт шалгалт хийж, улсын ахлах байцаагчдын 2025 оны 01 дүгээр сарын 02-00-00-001/27 дугаар албан шаардлагыг өгч, дотор ханын материал өөрчилсөн зөчилд Зөрчлийн тухай хуулиар 10.000.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээг авч ажиллан ХХААХҮЯ-д 2025.02.21-ний өдрийн 03/697 дугаар албан бичгээр хариуг өгсөн. “Аутсайд | 2025.01.02<br>2025.05.31 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сервис” ХХК-иас 2025.05.08-ны өдрийн 39/25 дугаар албан бичгээр биелэлтийг ирүүлсэн бөгөөд биелэлт 96 хувийн гүйцэтгэлтэй.<br>2. Иргэн Ц.Төмөрийн гаргасан гомдлын дагуу Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 02-00/02 дугаар удирдамжийн дагуу Сүхбаатар дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах орон сууцны 22 дугаар байрны 3 давхарт нийтийн эзэмшлийн талбайд хаалт, өргөтгөл хийсэн байдалд Зөрчлийн тухай хуулиар 2025.01.23-ны өдрийн 02-00-003/02 дугаартай хялбаршуулсан журмаар шийдвэрлэн, 500000 төгрөгийн торгууль ногдуулж, бүрэн барагдуулсан, эрх бүхий албан тушаалтны даалгавар өгч, иргэн Ц.Төмөрт 2025.02.05-ны өдрийн 11/412 тоот албан бичгээр хариуг өгсөн.<br>3.ТЕГ-ын барилгад хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн улсын ахлах байцаагчийн дүгнэлтийг гарган нууцын албан бичгээр хүргүүлсэн.<br>4.Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн хүсэлтийн дагуу үйлчилгээтэй, орон сууцны 51а байрны барилгын 1 дүгээр давхрын ашиглалтын төлөв байдалд хяналт шалгалтыг хийж | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2025.02.27-ны өдрийн 02-00-01/003/13 дугаар улсын ахлах байцаагчийн дүгнэлтийг гарган 2025.02.28-ны өдрийн 11/816 дугаар албан бичгээр хариуг өгсөн.<br>5.Иргэн П.Баяраагаас ирүүлсэн гомдлын дагуу үерийн хамгаалалтын сувагт хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн 2025.02.25-ны өдрийн 11/730 тоот албан бичгээр хариуг өгөв.<br>6.Боловсролын яамтай хамтран Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2025 оны 03-00/04 дугаар удирдамжийн дагуу ерөнхий боловсролын “Өнөр” сургуулийн хичээлийн 3 дугаар байрны барилгын ашиглалтын төлөв байдалд 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдөр хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн хяналт шалгалтын танилцуулгыг БЯ-д хүргүүлсэн.<br>6.Иргэн З.Сайн-Өндөрийн гаргасан гомдлын дагуу Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 02-00/02 дугаар удирдамжийн дагуу Хан-Уул дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах “Юнитра” ХХК-ийн захиалгатай агуулахын барилгад хяналт шалгалт хийсэн. Хяналт шалгалт хийж гүйцэтгэн Зөрчлийн тухай хуулийн дагуу ХББОСЯ 02-00-006/29 дугаартай хялбаршуулсан журмаар арга | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэмжээ авч, шийтгэл оногдуулсан талаар 2025.03.31-ний өдрийн 11/1083 дугаар албан бичгээр хариуг өгсөн.<br>7.УИХ-ын гишүүн Ч.Лодойсамбуугаас ирүүлсэн албан бичгийн дагуу Хот байгуулалт, хотын стандартын газраас 2024.12.24-ний өдрийн 11/1987 тоот албан бичгээр гомдолд дурдсан яаманд архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зураг баталсан эсэх, барилгын ажлын зөвшөөрөл олгосон эсэх, Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанаас газар олгосон эсэх асуудлыг тодруулах, нотлох баримт гаргуулахаар 2024.12.25-ны өдрийн 11/1988 тоот албан бичгийн хариуг 2025.0.02-ны өдөр албан бичгээр ирүүлсэн. Мөн Боловсролын яамны Хан-Уул дүүргийн 11 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах барилгад Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 02-00/02 дугаар удирдамжийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн БЯ, "Зайсан сүлд" СӨХ-д 2025.03.27-ны өдрийн 11/910 дугаар албан бичгээр хариуг хүргүүлсэн.<br>8.ЗГХЭГ-аас 2025.03.27-ны өдрийн ХЭГ/847 тоот албан бичгийн дагуу "Камдер" ХХК-ийн барилга холбоотой авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мэдээлэл авахаар | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | нийслэлийн Засаг даргад 2025.04.08-ны өдрийн 01/1211 тоот албан бичиг хүргүүлсэн. Тус албан бичгийн дагуу хяналт шалгалтуудыг хийж гүйцэтгэн хариуг 2025.04.24-ний өдрийн 01/1464 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br>9. ХУД, 18 хороо, Хүннү-2222 хотхоны 222 дугаар байрны 1405, нийтийн эзэмшлийн талбайн ашиглалтын төлөв байдалд хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн 2025.04.22-ны өдрийн 02-00-01/003/77 дугаар албан шаардлагыг иргэн С.Уртбаярт өгч, 2025.04.22-ны өдрийн 11/1435 тоот албан бичгээр, мөн иргэн Д.Оюунцэцэгт 2025.04.22-ны өдрийн 11/1434 тоот албан бичгээр хариуг хүргүүлсэн.<br>10. ХУД, 18 хороо, Гэрлүг виста хотхоны 58/4 дугаар байрны ашиглалтын төлөв байдал, нийтийн эзэмшлийн газрын ашиглалтад ГЗБГЗЗЕГ-тай хамтарсан хяналт шалгалтыг хийж гүйцэн нийтийн эзэмшлийн зам талбайг чөлөөлүүлж, барилгын хийц бүтээц, төлөвлөлтийн өөрчлөхгүй байх үүрэг даалгаврыг 2025.04.22-ны өдрийн 1420 тоот албан бичгээр "Крио Монгол" ХХК-д өгч, хариуг "Гэрлүг виста" СӨХ-д 2025.04.22-ны өдрийн 11/1421 тоот албан бичгээр өгсөн.<br>11.Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс ирүүлсэн хүсэлтийг судалж танилцаад хариу талбайр, нотлох | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | баримтыг гарган 2025.03.26-ны өдрийн 08/1041 тоот албан бичгээр хариуг өгсөн. Шүүх хурал 2025.05.12-ны өдөр болж, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон. | | |
| 8.2.8. | Өмнөх шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар өгсөн албан шаардлагын биелэлтийг хангуулахаар гүйцэтгэлийн хяналт шалгалт хийх; | Гүйцэтгэлийн хяналт шалгалт хийсэн тоо | 2024 онд 2 объектод албан шаардлагын биелэлтийг хангуулахаар гүйцэтгэлийн хяналт шалгалтыг хийсэн. | - | Тайлант хугацаанд 2 объектод гүйцэтгэлийн хяналт шалгалтыг хийсэн.<br>1.Гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд хэрэгжиж буй "Ногоон нуур 1008 айлын орон сууц" төслийн орон сууцны зориулалттай 8 блок барилгад хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн улсын ахлах байцаагчдын 2024 оны 02-00-01/003/133 дугаартай нэгдсэн албан шаардлага өгсөн албан шаардлагын биелэлт гүйцэтгэлийн хяналт шалгалт хийхэд 85 хувьтай байна.<br>2.Солонго 1, 2 төслийн хүрээнд баригдаж буй орон сууцны 63 барилгад хяналт шалгалтыг хийж, улсын ахлах байцаагчдын 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 02-00-02/004/06 дугаар албан шаардлагын биелэлтэд гүйцэтгэлийн хяналт шалгалт хийхэд биелэлт 65 хувьтай байна. | 2025.01.02<br>2025.05.31 | - |
| 8.2.10. | "Шар усны болон үерийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангуулах тухай" албан даалгавар боловсруулан батлуулж, аймаг, нийслэлийн Засаг | -Албан даалгавар-1<br>-Албан даалгаврын хэрэгжилтийг нэгтгэсэн байдал; | "Үерээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангуулах тухай" БХБС-ын 2023 оны 2023/02 дугаар албан | Албан даалгаврын батлуулан аймаг, нийслэлийн Засаг дарга нарт хүргүүлсэн байна. | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын "Шар усны болон уруйн, хур борооны үерээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах тухай" 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 2025/02 дугаар албан даалгаврыг харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлж, барилга байгууламжийн үйл ажиллагаа | 2025.01.02<br>2025.02.21 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дарга нарт хүргүүлж, биелэлтийг нэгтгэх; | | даалгаврыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт хүргүүлж, биелэлтийг нэгтгэсэн байна. | | эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад хүргүүлж, хяналт тавьж ажиллах талаар 2025.02.21-ний өдрийн 1/693 тоот албан бичгээр аймаг, нийслэлийн Засаг даргад, 2025.02.21-ний өдрийн 11/663 тоот албан бичгээр аймгийн ГХБХБГ, нийслэлийн Хяналт шалгалтын газар, Хот байгуулалт, хотын стандартын газар, Геодези, усны барилга байгууламжийн газар, Монголын Үндэсний Асициаци ТББ, Монголын барилгачдын инженерүүдийн холбоо ТББ, холбогдох байгууллагад хүргүүлж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. | | |
| 8.2.11. | "Барилга байгууламжийн чанар аюулгүй байдлыг хангуулах тухай" албан даалгавар боловсруулан батлуулж, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт хүргүүлж, биелэлтийг нэгтгэх; | -Албан даалгавар-1<br>-Албан даалгаврын хэрэгжилтийг нэгтгэсэн байдал; | "Барилгын ажлын аюулгүй байдлыг хангуулах зарим арга хэмжээний тухай" БХБС-ын 2023 оны 2023/02 дугаар албан даалгаврыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт хүргүүлж, биелэлтийг нэгтгэсэн байна. | Албан даалгаврын батлуулан аймаг, нийслэлийн Засаг дарга нарт хүргүүлсэн байна. | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын "Барилга байгууламжийн чанар аюулгүй байдлыг хангах тухай" 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 2025/01 дугаар албан даалгаврыг харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлж, барилга байгууламжийн үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад хүргүүлж, хяналт тавьж ажиллах талаар 2025.02.21-ний өдрийн 1/693 тоот албан бичгээр аймаг, нийслэлийн Засаг даргад, 2025.02.21-ний өдрийн 11/663 тоот албан бичгээр аймгийн ГХБХБГ, нийслэлийн Хяналт шалгалтын газар, Хот байгуулалт, хотын стандартын газар, Геодези, усны барилга байгууламжийн газар, Монголын Үндэсний Асициаци ТББ, Монголын | 2025.01.02<br>2025.02.21 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | барилгачдын инженерүүдийн холбоо ТББ, холбогдох байгууллагад хүргүүлж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. | | |
| **Удирдлагаас өгсөн чиглэл, үүрэг даалгаврын хүрээнд:** | | | | | | | |
| 8.2.12. | | | | | | | |
| **Салбарын сургалт зохион байгуулах ажлын хүрээнд:** | | | | | | | |
| 8.2.13. | Салбарын хяналтын улсын байцаагч нарт зориулсан сургалтыг цахим болон танхимын зохион байгуулах; | Сургалтыг цахимаар зохион байгуулсан | Сургалтад 45 улсын /ахлах/ байцаагчид хамрагдсан. | Сургалтыг зохион байгуулсан байна. | “Аймаг, нийслэлийн хот байгуулалт, барилгын салбарын улсын (ахлах) байцаагчдыг чадавхжуулах, туршлага солилцох сургалт”-ыг 2025.02.10-ны өдрийн цахим сургалт, 2025.02.13-14-ны өдрүүдэд танхимын сургалт зохион байгуулахтай холбоотойгоор хамтран ажиллах тухай Төрийн албаны зөвлөл, Улсын Ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Хяналт хэрэгжүүлэх газар, Монголын Барилгын инженерүүдийн холбоо ТББ-д 2025.01.28-ны өдрийн 3/314 тоот, 2025.02.05-ны өдрийн 11/431, 11/433, 11/432 тоот албан бичиг, аймгийн ГХБХБГ, нийслэлийн ХШГ-т улсын байцаагчдыг сургалтад хамруулах тухай 2025.02.06-ны өдрийн 11/430 тоот албан бичгийг хүргүүлсэн. Тус сургалтын хөтөлбөрийг боловсруулан ХББОСЯ-ны ТНБД-аар батлуулсан.<br>Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Салбарын хяналтын газраас | 2025.01.02<br>2025.02.15 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Нийслэлийн хяналт шалгалтын газрын Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтэстэй хамтран хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын салбарын хяналтын улсын (ахлах) байцаагчдыг чадавхжуулах, мэдлэг, ур чадварыг дээшлүүлж, мэргэшүүлэх, салбарын төрөөс баримтлах бодлого, анхаарах асуудал, хяналт шалгалтын ажлын гүйцэтгэл, үр нөлөөг сайжруулах, болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх, техникийн аюулгүй ажиллагааг хангуулах, тулгамдаж байгаа асуудлаар санал солилцох, туршлага судлах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх зорилготой сургалтыг 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдөр цахимаар, 2025 оны 02 дугаар сарын 13-14-ний өдрүүдэд танхимаар зохион байгууллаа.<br>Сургалтад Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Салбарын хяналтын газар, Нийслэлийн хяналт шалгалтын газрын Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн улсын (ахлах) байцаагч болон албан хаагчид, 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын техникийн хяналт, барилга байгууламжийн техникийн хяналт, өргөх байгууламжийн хяналтын нийт 62 улсын (ахлах) байцаагчид хамрагдсан.<br>Хяналт, үнэлгээний Үндэсний хороо, Ёс зүйн хороо, Цахим | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар, Улсын ерөнхий Прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газар, Япон Улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (Жайка)-ын Монгол Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх төсөл, “Монкон” ХХК, “Монголын Ажил Олгогчдын Эвлэлийн Нэгдсэн Холбоо” ТББ, “Харилцагчийн зөвлөх Полиси төв” зэрэг байгууллагаас илтгэл мэдээллийг хийж, хамтран ажилласан. | | |
| **Байгууллагын тайлагнах үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх ажлын хүрээнд:** | | | | | | | |
| 8.2.14. | Яамны цахим болон дотоодын ээлжит, ээлжит бус шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангаж ажиллах; | Тухайн жилд өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн хувь | Сайдын шуурхайгаас 2, Төрийн нарийн бичгийн даргаас өгсөн 1 үүрэг даалгаврын биелэлтийг тухай бүр нь 100 хувь хангаж ажилласан. | Яамны цахим болон дотоодын ээлжит, ээлжит бус шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг 100 хувь хангуулсан байна. | Газрын даргаас өгсөн үүрэг даалгаврын дагуу Сайдын шуурхайгаас өгсөн 2 үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж, газрын даргад танилцуулсан. | 2025.01.02<br>2025.05.31 | 100 |
| 8.2.15. | Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль | -Салбарын хяналтын газрын ХАСХОМ-ийг мэдүүлгийн гаргуулсан тоо | ХАСХОМ-ийг гаргасан. | ХАСХОМ-ийг гаргасан байна. | ХАСХОМ-ийг мэдүүлгийн 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдөр гаргаж өгсөн. | 2025.01.02<br>2025.05.31 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлэх; | | | | | | |
| 8.2.16. | Зөрчлийн талаарх гомдол мэдээллийг нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, хуулийн дагуу арга хэмжээ авах; | Зөрчлийн талаарх гомдол мэдээллийн нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, хуулийн дагуу авсан арга хэмжээ | 3 зөрчлийн хэрэг бүртгэлийг бүртгүүлж,<br>Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу холбогдох арга хэмжээ авсан. | Зөрчлийн талаарх гомдол мэдээллийн нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, хуулийн дагуу арга хэмжээг авсан байна. | 1.Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу зөрчлийн талаарх 1 гомдол мэдээллийг нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, 1 иргэнд хялбаршуулсан журмаар эрх бүхий албан тушаалтны даалгавар өгч, 500.000 төгрөгийн шийтгэлийн арга хэмжээг авч, бүрэн барагдуулж ажилласан.<br>2.Улсын Ерөнхий прокурорын газраас ирүүлсэн албан бичгийн дагуу “Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан”-г хэрэглээнд нэвтрүүлэх эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан сургалтыг хамтран зохион байгуулж, сургалтад хамрагдсан. | 2025.01.02<br>2025.05.31 | 100 |
| 8.2.17. | Иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн хариутай албан бичиг, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, хөтлөгдөж дууссан баримт бичгийг архивт хүлээлгэн өгөх. | 1.Албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь<br>2.Архивт хүлээлгэн өгсөн архивын нэгж. | 2024 онд 77 албан бичиг,12 өргөдөл гомдлыг 100 хувьтай шийдвэрлэж, архивт хүлээлгэн өгсөн. | Иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн хариутай албан бичиг, өргөдөл, гомдлыг 100 хувь шийдвэрлэн, хөтлөгдөж дууссан баримт бичгийг архивт хүлээлгэн өгсөн байна. | Тайлант хугацаанд албан бичиг хүлээж авсанаас хариутай албан бичиг 72 албан бичиг, 5 өргөдлийг хүлээн авч, шийдвэрлэн, 68 албан бичиг боловсруулан гаргаж архивт хүлээлгэн өгсөн. Мөн хяналт шалгалтыг ахалж улсын ахлах байцаагчийн 2 дүгнэлт, 4 албан шаардлага, 1 зөрчлийн хэрэг, 2 албан даалгавар, 6 тушаал боловсруулан гаргаж архивт хүлээлгэн өгсөн. | 2025.01.02<br>2025.05.31 | 100 |

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ны биелэлт

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт / | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлт хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.1 | **Үүрэг даалгавар 1:** Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын дагуу улсын байцаагчийн эрх олгох, цуцлах тушаал, танилцуулга гаргах. | Улсын байцаагчид олгосон эрх, цуцалсан тоо | - | Улсын байцаагчид эрх олгосон байна. | Тайлант хугацаанд сайдын 5 тушаалаар улсын (ахлах) байцаагчийн 12 эрх цуцалж, 20 улсын (ахлах) байцаагчийн эрх олгосон. 2 улсын байцаагчид эрх олгохоос татгалзсан хариуг хүргүүлсэн.<br>1.Орхон, Говь-Алтай аймгийн ГХБХБГ-аас ирүүлсэн хүсэлт, СХГ-т шинээр томилогдсон 2 байцаагчдын материалыг судалж, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025.01.31-ний өдрийн 31 дүгээр тушаалаар 4 улсын /ахлах/ байцаагчдад эрх олгож, 1 улсын ахлах байцаагчийн эрхийг цуцалсан. Орхон, Говь-Алтай аймгийн ГХБХБГ-т 2025.02.05-ны өдрийн 11/410, 11/411 тоот албан бичгээр тушаалыг хүргүүлсэн.<br>2.Завхан аймгийн ГХБХГ-аас улсын ахлах байцаагчийн эрх хүсэх тухай албан бичгийн судалж танилцахад Засгийн газрын 2023 оны 06 дугаар тушаалаар батлагдсан “Хяналтын улсын байцаагчийн эрх олгох, цуцлах журам”-д заасан баримт бичгийн шаардлага хангахгүй байсан тул эрх олгох боломжгүй талаар 2025.02.25-ны өдрийн 11/733 тоот албан бичгээр хариуг хүргүүлэв. | 2025.01.02<br>2025.05.31 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 3.Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний газраас ирүүлсэн “Эрх авах тухай” албан бичгийг судалж танилцан ХББОСС-ын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 144 дугаар тушаалаар улсын байцаагчийн эрхийг олгож, тус хороонд тушаалыг 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 11/96 тоот албан бичгээр тушаалыг хүргүүлсэн.<br><br>4. Баянхонгор, Сэлэнгэ, Дорнод, Дундговь, Дорноговь, Дархан-Уул, Хөвсгөл, Төв, Увс, Говьсүмбэр аймгийн ГХБХБГ, Нийслэлийн Хяналт шалгалтын газраас ирүүлсэн хүсэлтийн дагуу 9 байцаагчийн эрх цуцлах, 12 байцаагчид эрх олгох ХББОСС-ын 2025.04.01-ний өдрийн 72 дугаар тушаалаар олгосныг 2025.04.03-ны өдрийн 11/1129 дугаар албан бичгээр хүргүүлсэн.<br><br>5.Нийслэлийн Хяналт шалгалтын газраас ирүүлсэн “Улсын байцаагчийн эрх авах тухай” албан бичгийг судалж танилцаад 2025.03.26-ны өдрийн 1040 тоот албан бичгээр улсын байцаагчийн эрх олгох боломжгүй талаар хариуг өгсөн.<br><br>6.Хэнтий аймгийн ГХБХБГ, Завхан аймгийн ЗД-аас ирүүлсэн хүсэлтийн дагуу 2 улсын (ахлах) байцаагчийн эрхийг цуцалж, 2 улсын ахлах байцаагчийн эрхийг олгосон ХББОСС-ын 2025.05.07-ны өдрийн 104 дүгээр тушаалаар | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | олгосныг 2025.05.08-ны өдрийн 03/1684 дугаар албан бичиг, 2025.05.21-ний өдрийн 11/1886 дугаар албан бичгээр тус тус хүргүүлсэн.<br>7.Нийслэлийн хяналт шалгалтыг газраас ирүүлсэн хүсэлтийн дагуу ХББОСС-ын 2025.05.25-ны өдрийн 125 дугаар тушаалаар улсын байцаагчийн эрхийг олгосныг 2025.05.28-ны өдрийн 11/2112 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | | |
| 1.2. | **Үүрэг даалгавар 2:** Аюулгүй барилга-Аюулгүй ажиллагаа" 2 сарын аян зохион байгуулах | Аян зохион байгуулсан эсэх | - | Аянг зохион байгуулсан байна. | Барилга байгууламжийн чанар, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, техник, технологийн аюулгүй байдал, учирч болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор "Аюулгүй барилга-Аюулгүй ажиллагаа" аяныг зохион байгуулах тухай 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 100/А101 дугаартай хамтарсан тушаал, Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, удирдамж, төлөвлөгөөг гарган баталж, улсын хэмжээнд 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдрөөс 06 дугаар сарын 30-ны өдөр хүртэл зохион байгуулан ажиллаж байна. Тус аяныг зохион байгуулах талаар аймаг, нийслэлийн Засаг дарга нар, аймгийн ГХБХБГ, ХХҮГ, ХБХСГ, БХТ, ТББ-дад 2025.05.13-ны өдрийн 01/1750 тоот албан бичгээр тушаал, удирдамж, төлөвлөгөөг хүргүүлсэн.<br>Тус аяны хүрээнд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын | 2025.05.01<br>2025.05.31 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | яамны сайд, Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны сайдын 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 100/А101 дугаартай хамтарсан тушаалын дагуу барилга, байгууламжийн чанар, байдал, учирч болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор "Аюулгүй барилга-Аюулгүй ажиллагаа" аяны хүрээнд ХББОСЯ-Төрийн нарийн бичгийн даргын баталсан сургалтын хөтөлбөрийн дагуу Увс аймгийн барилгын угсралтын үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж байгууллагуудад зориулсан сургалтыг 2025.05.16-ны өдөр аймгийн ЗДТГ, ГХБХБГ, Баян-Өлгий аймгийн ХХҮГ-тай хамтран зохион байгуулсан бөгөөд сургалтад 47 ААН-ийн 60 гаруй захирал, ИТА хамрагдсан.<br><br>Аймаг, нийслэлээс "Аюулгүй барилга-Аюулгүй ажиллагаа" сарын аяны хүрээнд 36 удаагийн сургалтыг зохион байгуулж, 1518 иргэн, аж ахуйн нэгжийн ИТА, удирдлагуудыг хамруулсан.<br><br>Улсын хэмжээнд аяны хүрээнд 2734 объектод хяналт шалгалтыг гүйцэтгэж, хяналт шалгалтаар илэрсэн 1936 зөрчил дутагдлаас 928 зөрчлийг арилгуулж, хууль сахин мөрдөлтийн хэрэгжилтийг 48%-тай хангуулан, улсын байцаагчийн 241 албан шаардлага, 20 акт, 452 дүгнэлт, 100 зөвлөмжийг гаргаж, 169 иргэн, хуулийн этгээдэд 421.7 сая | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төгрөгний торгуулийн арга хэмжээ ноогдуулсан байна. | | |

Хоёр Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ биелэлт

| “ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | ШХИС-д эрх зүйч мэргэжлээр суралцах | Эрх зүйч мэргэжлээр суралцаж буй байдал; | Эрх зүйч мэргэжлээр 1 ангид суралцсан. | Эрх зүйч мэргэжлээр 2 ангийн эхний хагас жилийг суралцсан байна. | 1. Шихихутуг их сургуульд эрх зүйч мэргэжлээр 2 курсын эхний ангид суралцаж төгссөн.<br>2. Улсын Ерөнхий прокурорын газраас зохион байгуулсан “Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан”-г хэрэглээнд нэвтрүүлэх эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан сургалтад хамрагдсан.<br>3.Авлигатай тэмцэх газраас 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулсан “Авлига, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтад хамрагдсан.<br>4.ТНБД-ын 2025.05.14-ний өдрийн Б/68 дугаар тушаалаар Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Берлин хотод Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгээс 2025 оны 06 дугаар сарын 01-07-ны өдрүүдэд зохион байгуулах “Төслийн түншлэгч талуудын барилгын дулаан шинэчлэл, барилгын эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх, дулааны хэрэглээнд суурилсан үнэ тариф болон санхүүгийн тогтвортой механизмыг нэвтрүүлэх боломжийг нэвтрүүлэх нь” арга хэмжээнд туршлага судлах | 2025.03.01<br>2025.05.20 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сургалтад 2025.06.01-06.07-ны өдрүүдэд хамрагдсан. | | |

ТАЙЛАН ГАРГАСАН:

АХЛАХ ШИНЖЭЭЧ, БАРИЛГЫН ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ ........................ /Д.ГАНЧИМЭГ/

*(Албан тушаал)* *(Нэр, гарын үсэг)* *(Огноо)*